



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

1

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нь зээл хүссэн өргөдөл, зээлийн материалаа банк, санхүүгийн байгууллагад өгнө.

2

Банк, санхүүгийн байгууллага нь зээл олгох дүгнэлтээ Зээлийн батлан даалтын санд ирүүлнэ.

3

Зээлийн батлан даалтын сан нь ирүүлсэн материалыг нягтлан үзээд зөвшөөрвөл Зээлдэгч болон Банк, санхүүгийн байгууллагатай Батлан даалтын гэрээ байгуулна.

4

Банк, санхүүгийн байгууллага нь Батлан даалтын гэрээнд үндэслэн батлан даалттай зээлийг олгоно.

5-1

Зээлдэгч нь батлан даалтын шимтгэл төлөхийг зөвшөөрнө.

5-2

Банк, санхүүгийн байгууллага нь батлан даалтын шимтгэлийг олгох зээлээс суутган Зээлийн батлан даалтын сангийн данс руу шилжүүлнэ.



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТ ХҮСЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,
Оранж плаза 305, 306 тоот

Бидэнтэй холбоо барих утас: 7011-0057, 7011-0058,
Факс: 7011-0059;

Вэб хаяг: <http://www.lgf.mn>, и-мэйл: cgf@lgf.mn

Зээлийн батлан даалт хүсэгчдэд

Эрх зүйн зохицуулалт: Монгол Улсын “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хууль 2012 оны 2-р сарын 10-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан.

Батлан даалт гаргагч: Зээлийн Батлан Даалтын Сан

Батлан даалт хүсэгч нь:

1. Зээлийн барьцаа хөрөнгө дутагдалтай байгаа жижиг дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг “Жижиг дунд үйлдвэрийн тухай” хуулийн 5-р зүйлд заасан шаардлага хангасан аж ахуйн нэгж, иргэн,
2. Жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгж, иргэн.

Батлан даалтын хүсэлт хүлээн авагч: Зээлийн Батлан Даалтын Сантай гэрээ байгуулсан банк, санхүүгийн байгуулага, түүний салбар, нэгж.

Батлан даалтын төрөл: Эргэлтийн хөрөнгийн, Хөрөнгө оруулалтын, Бичил зээлийн.

Батлан даалтын хэмжээ: Нэг зээлдэгчид олгох зээлийн 60 хүртэлх хувиас илүүгүй, нэг удаа батлан даалт гаргах дээд хэмжээ 250.0 сая төгрөг хүртэл.

Батлан даалтын хугацаа: Зээлдэгч болон банк, санхүүгийн байгууллага хооронд байгуулсан зээлийн гэрээний хугацаанаас хэтрэхгүй байна.

Үйлчилгээний хураамж: Батлан даалт гаргуулсан эсэхээс үл хамааран 10000 /арван мянга/ төгрөг.

Батлан даалтын шимтгэл:

Батлан даалтын хугацаанаас хамааруулан дараах хувиар нэг удаа батлан даалтын хэмжээнээс тооцон төлнө. Үүнд:

- 1 жил хүртэл хугацаанд - 1.0 %
- 1-2 жил хүртэл хугацаанд - 2.0 %
- 2-оос дээш жилийн хугацаанд - 3.0 %

Батлан даалт гаргах үйл ажиллагааны ерөнхий схем

